

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-7

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай/ 3-7

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны
12 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 09 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Х.Баделхан;
Чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Т.Энхболд, нэр дэвшигч Д.Дуламсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар тус тус танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан үг хэлэв.

Н.Энхболд: Доржсүрэнгийн Дуламсүрэнг Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр сонгох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: “Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
11 цаг 09 минут.

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна. Адъяаа гишүүн, Бейсен гишүүн, Баярсайхан гишүүн, Энхболд гишүүн, Бейсен гишүүн, Энх-Амгалан гишүүн, Энхбаяр гишүүн нар хүрэлцэн ирсэн, ирц 60 хувьтай учраас хуралдаанаа нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу албан ёсоор нэрийг нь танилцуулчихлаа. Бусад гишүүд маань чөлөөтэй, томилолттой байгаа. Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ийм танилцуулга, шалгаруулах ажиллагаа явагдана. Бид нар урьд нь Төрийн албаны зөвлөлийн хуулийн дагуу Ёс зүйн хорооны гишүүдийг сонгон шалгаруулах ажлаа хэд хэдэн үе шаттайгаар 2 дахь удаагаа зохион байгуулж байна.

Одоо 9 дэх буюу хамгийн сүүлчийн гишүүнийг томилоод ингээд Ёс зүйн хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилдаа орох ийм боломж нь бүрдэх юм байгаа юм. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна. Асуудалдаа орцгооё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай/

Сонгон шалгаруулалт хийсэн дүнгийн талаарх ажлын хэсгийн

танилцуулгыг нарийн бичгийн дарга Энэбиш танилцуулна.

Х.Энэбиш: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалт, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос баталсан Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.8-д заасны дагуу Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх ажлын хэсгийн тайланг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд танилцуулж байна.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Энхболдоор ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Бейсен, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Энэбиш, ХЭҮК-ын Тамгын газрын дарга Адъяахишиг, ЗГХЭГ-ын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сувдмаа, ТАЗ-ийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ, АТГ-ын Хянан шалгах, дүн шинжилгээ хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Энхболд, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Жолбарс нарын 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ажлын хэсэг нийт 6 удаа хуралдаж, 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 3 гишүүнийг сонгон шалгаруулж, ажилд нь оруулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар Ёс зүйн хорооны орон тооны бус 4 гишүүнийг ажиллах тул ажлын хэсэг дахин нэг гишүүнийг сонгон шалгаруулахаар ажиллалаа. Монгол

Улсын Их Хурлын тухай, Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 2 дугаар хавсралтаар нэр дэвших тухай хүсэлт, 3 дугаар хавсралтаар ажлын хэсгийн гишүүний баталгааг баталсны дагуу ажлын хэсгийн хуралдаан өмнө нь ажлын хэсгийн гишүүнээс зохих баталгааг гаргуулж авсан тул уг баталгааг дахин гаргах шаардлагагүй гэж үзлээ.

Ажлын хэсгээс сонгон шалгаруулах тухай зарыг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Өдрийн сонин, МҮОНТ Цагийн хүрд нэвтрүүлэг, Улсын Их Хурлын цахим сайт parliament.mn, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны цахим сайт, ТАЗ-ийн цахим сайт болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал сүлжээг ашиглан нийтэд мэдээлсэн. Нэр дэвшүүлэх хугацааг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 6-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл зарласны дагуу иргэдийн хүсэлтийг цахимаар болон бичгээр хүлээн авсан бөгөөд 5 хүн хүсэлтээ гаргаж, холбогдох материалаа ирүүлсэн. Нэр дэвшигчийн хүсэлт, холбогдох материалтай Ажлын хэсэг 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа танилцан сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг хэлэлцэх хүсэлт материал ирүүлсэн 5 хүнээс журамд заасан материалын бүрдлийг дутуу ирүүлсэн 2 нэр дэвшигчийн асуудлаар санал хураалт явуулж, Ажлын хэсгийн олонхын саналаар бүртгэхээс татгалзсан болно. Мөн журамд заасны дагуу ажлын хэсэг нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, баримт судлах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын сарын 20-ны хооронд АТГ, БСШУЯ, УБЕГ, НДЕГ, ЦЕГ-аас болон нэр дэвшигчээс тодруулга, лавлагаа, мэдээлэл гаргуулан авсан.

Ажлын хэсгийн гишүүд 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэрээ дэвшүүлсэн Ванчигийн Удвал, Нацагдоржийн Бямбадорж, Доржсүрэнгийн Дуламсүрэн нартай Төрийн ордны Их засаг танхимд тус тусад нь ярилцлага зохион байгууллаа. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Төрийн ордны Үндсэн хууль танхимд ажлын хэсгийн хуралдааныг хийж, нэр бүхий хүнийг томилох дүрэм, журмын болзол хангасан гэж үзэн санал хураалтад оруулах нь зүйтэй гэж үзсэн. Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрмийн 7.1.1-д Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаах насны дээд хязгаар хүрсэн бол чөлөөлөх тухай заасан байх тул уг асуудлыг хэлэлцэн ажлын хэсгийн олонхын саналаар В.Удвалыг нууц санал хураалтад оруулаагүй байхаар, оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

Нууц санал хураах ажлын тооллогын комиссыг Улсын Их Хурлын гишүүн Бейсенээр ахлуулж, нарийн бичгийн даргаар Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Энэбиш, гишүүнээр АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссоор Энхболд нар ажиллалаа. Тооллогын комиссоос нууц нууцлал бүхий саналын хуудсыг баталж, нууцаар санал хураалт явуулахад Нацагдоржийн Бямбадоржийг олонхын саналаар дэмжээгүй бөгөөд Доржсүрэнгийн Дуламсүрэнг 100 хувийн саналаар дэмжсэн болно. Энэ дүнг харгалзан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хуралдаанд хамгийн олон санал авсан Доржсүрэнгийн Дуламсүрэнг оруулж танилцуулж байна.

Н.Энхболд: Нарийн бичгийн дарга Энэбиш-д баярлалаа. Ажлын хэсгээс болоод нэр дэвшигчээс асуух асуулттай хүн байвал нэрээ өгье. Байхгүй байна. Тэгвэл одоо санал хураалт явуулна.

Тогтоолын төслөө аваад ир. Дэгийн дагуу үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байвал нэрээ өгье. Баярсайхан гишүүний микрофоныг өгье.

Б.Баярсайхан: Өнөөдөр Ёс зүйн хороонд Доржсүрэнгийн Дуламсүрэн бас нэр дэвшиж орж ирж байгаад миний хувьд бол дэмжиж байна. Ингээд Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулиа бид нар баталсан. Монгол Улсын ЗГ ер нь улс үндэстнээрээ л бүгдээрээ авлигаасаа салъя, нэг ёс зүйтэй нийгмийг бүтээе. Энэ ялангуяа энэ дээр төрийн түшээд нь, өндөр албан тушаалтнууд нь, төрийн албан хаагч нар нь манлайлга гээд ингээд зорилго тавиад явж байгаа.

Би Дуламсүрэнг болбол АТГ ажиллаж, нэлээн олон жил энэ тал дээр мэргэшсэн, ер нь бол шударга үнэний дуу хоолой болоод энэ Ёс зүйн хороондоо бас нэлээн манлайлаад ажиллана гэж итгэж байна. Тэгээд одоо бүгдээрээ тал талдаа л энэ асуудал дээр анхаарахгүй л бол үр хүүхдэдээ бид нар ямар нийгэм үлдээх юм бэ гэдэг асуудал чинь их бүрхэг болчихоод байна. Тэгээд бараг хүний эрхийг зөрчсөн гэмээр хуулиудыг хүртэл дээгүүрээ баталж байна шүү дээ. Их Хурлын гишүүдээс авхуулаад, сайд өндөр албан тушаалтай хүмүүс бараг л ганц бие байхаар ёстой юм шиг, ингээд гэр бүл, үр хүүхдүүдийнх нь боломжийг нь хүртэл хаасан энэ хуулийг батлахдаа энэ цагийн золиос болж, энэ авлигыг ямар хугацаанд арилтал нь энэ зүйлийг хэвшүүлэх юм, энэ ёс зүйг хэвшүүлэх юм, энэ авлигаасаа салах юм гэдэг дээр Их Хурлын гишүүд дуу нэгтэй ингээд нэгдээд ингээд ийм хуулиуд батлагдаж байгаа. Юм, цаг их өөр болж байна. Тийм учраас энэ та нар, та нар дээр минь ялангуяа энэ хууль өөрчлөгдлөө, хороо нь байгуулагдлаа, холбогдох хуулиуд нь батлагдлаа. Ядаж төрийн албанд ёс зүй цэгцэрнэ гэж бодож байна. Тэгж найдаж байгаа.

Миний удаа дараа хэлдэг энэ төрийн түшээд гэхээсээ илүүтэйгээр дунд шатад байгаа энэ төрийн албан

хаагчдын ёс зүйн асуудлыг цэгцэлж, ялангуяа төрийн албанд анхнаас нь сонгон шалгаруулалт хийхдээ төлөвшсөн хүнийг оруулж ирэх энэ ажлыг эхлээч. Сингапурын төрийн албан алба шиг, Шинэ Зеландын төрийн төрийн алба шиг. Энэ бид нарын олон удаа турилага судлаад байгаа, гайхаж биширч хараад байгаа энэ хөгжсөн орнуудынхаа төрийн алба эхнээс нь яаж хүнээ бэлдүүлж, бэлдэж, гэр бүлийн түвшинд болон бага насандаа, залуу насандаа сайн мэдлэг сургуульд мэдлэг эзэмшиж, өндөр нэр төртэй сургуульд сурахаасаа илүү тэр хүн яаж төлөвшсөн юм бэ гэдэг энэ хандлагаас нь хүмүүсээ төрийн албанд оруулъя. Ингээд энэ гишүүд бүрдсэн гэж ойлгож байгаа. Тэгээд 200-гаад мянган төрийн албан хаагчдаа цэгцлэх, тэднийхээ сайнуудыг нь сургаж авах, мэргэшүүлэх, соён гэгээрүүлэх, муугаас нь салах, хариуцлагыг нь тооцуулах энэ ажлыг л манлайлж, түүчээлж, зоригтой хийгээрэй гэж ингэж хүсэж байна. Тэгээд амжилт хүсье, дэмжиж байна.

Н.Энхболд: Баярсайхан гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Дэгийн хуулийн тухай дагуу Ёс зүйн хорооны гишүүнийг нэр дэвшигчдээс нууцаар санал хурааж, тодруулах ёстой. Өнөөдрийн хуралдаанд нэг нэр дэвшигч орж байгаа. Хэдийгээр нэг ч гэсэн бид нар заавал нууцаар санал хураах дэгтэй учраас ажлын албыг санал хураалтаа нууцаар санал хураалгах хураах техникийн горимд шилжүүлэхийг хүсэж байна.

Ингээд ажлын хэсгээс санал болгож байгаа нэр дэвшигч Доржсүрэнгийн Дуламсүрэнгийн товч намтрыг танилцуулъя. Доржсүрэнгийн Дуламсүрэн 70 оны 10 сарын 16-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн сумд төрсөн, эмэгтэй, халх, нөхөр хүүхдийн хамт амьдардаг. 88 онд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр 10 жилийн дунд сургууль бүрэн дунд боловсролтой, 95 онд ОХУ-ын Иваново хотын Улсын их сургууль эрх зүйч мэргэжилтэй, 2003 онд ХБНГУ-ын

Бремен хотын Улсын их сургуульд магистрын цол хамгаалсан, 20 оноос Удирдлагын академид докторантаар байгаа. 95-аас 96 онд Хууль зүйн яамны Олон улсын эрх зүйн хамтын ажиллагааны газарт мэргэжилтэн, 96-аас 2007 онд Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2007-гоос 2010 онд АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст ажилтан, ахлах ажилтан, 2010-аас 12 онд АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст дарга, 2012-оос 17 онд АТГ-ын Судалгаа шинжилгээний албанд дарга, 2017-гоос 19 онд АТГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх албанд дарга, 19-өөс 22 онд мөн Газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст дарга, 22-оос 23 онд мөн Газрын авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны дарга, 23 оноос АТГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтэст албаны даргаар ажиллаж байна. Орос, англи, герман хэлтэй ийм хүн байгаа.

Бид нар түрүүн товч танилцуулсан. Сүүлчийн шатанд 3 хүн нэр дэвшиж орж ирээд, шалгууруудаа даваагүй болон тэгээд ярилцлагын дараа санал хурааж шалгаруулахад ингээд Доржсүрэнгийн Дуламсүрэн нэр дэвшигчээр үлдсэн байгаа. Ингээд санал хураалт явуулна. Нууцаар санал хураалт явуулна. Их Хурлын Байнгын хорооноос томилсон Ажлын хэсгээс санал болгож байгаа Доржсүрэнгийн Дуламсүрэнг ТАЗ-ийн Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр сонгох саналыг дэмжье гэсэн саналыг дэмжиж санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн учраас тогтоолоо батална. Байнгын хорооны тогтоолын төсөл танилцуулъя. Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь

заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооноос тогтоох нь.

1. Монгол Улсын Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд Төрийн албаны зөвлөлийн гэж үг нь энд урд нь байх ёстой шүү. Доржсүрэнгийн Дуламсүрэнг томилсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо Баттөмөр, Төрийн албаны зөвлөл Баатарзориг нарт даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна. Төслийн, төсөлтэй холбогдуулж асуух, санал, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Тогтоолыг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 66 аравны, хуралдаанд оролцсон гишүүдийн 66,7 хувиар тогтоол батлагдлаа. Ингээд Доржсүрэнгийн Дуламсүрэн Монгол Улсын ТАЗ-ийн Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр томилогдлоо. Баяр хүргэе, амжилт хүсье. Сая Баярсайхан гишүүн маань үг хэлэхдээ анхаарч ажиллах асуудал, та бүхэнд тавьж байгаа найдлагын талаар их тодорхой үг хэлсэн. Тэгэхээр энэ итгэлийг биелүүлж, өнөөдөр Монгол Улсад зайлшгүй шийдэх ёстой болчхоод байгаа, зайлшгүй анхаарах ёстой асуудал болчхоод байгаа, нийт нийгмийн хэмжээнд, төрийн албаны хэмжээнд ёс зүйг төлөвшүүлэх, энэ соёлыг бий болгох энэ шалгуур үзүүлэлтүүдээр төрийн албанд хүмүүсийг авч байдаг, томилдог энэ шалгуур үзүүлэлтээр тэр хүмүүсийн ажлыг дүгнэж байдаг энэ маш том хариуцлагатай ажил. Манай хууль бол анхдагч их том хууль байгаа Ёс зүй хариуцлагын тухай төрийн албаны. Энэ Ёс зүйн хороо бол бас анхны Ёс зүйн хороо болж байгаа. Үүгээрээ та бүхэн яаж ажиллана, энэ хэмжээгээр энэ Ёс зүйн хорооны соёл төлөвшил, өв уламжлал хадгалагдаж үлдэх ийм чухал томилолт болж байгаа гэдгийг сайн ойлгоорой.

Ингээд амжилт хүсье. Баярлалаа. Та гарч байж болно, амжилт хүсье.

11.26 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүд, Баярсайхан байж байгаарай, Бейсен гишүүнээ түр байж байгаарай. Та нар бас сууж байгаарай. Адьшаа гишүүн, Баярсайхан гишүүн, Бейсен гишүүн, Энх-Амгалан гишүүн, Энхбаяр гишүүн нартаа баярлалаа. Чухал ажилд хариуцлагатай оролцож байгаа. Ер нь манай энэ Байнгын хорооноос томилогдсон Ажлын хэсэг болбол маш сайн ажилласан. Би ажлын хэсгийн ахлагчаар ажилласан хүний хувьд ингэж дүгнэж байгаа. Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Бейсен, Тамгын газрын ахлах зөвлөх Энэбиш, Хүний эрхийн Комиссын Тамгын газрын дарга Адьяахишиг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг гүйцэтгэгч Сувдмаа, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Энхболд, Монголын Хуульчдын холбооны

Тамгын газрын дарга Жолбарс нар энэ ажлын хэсэгт ажилласан.

Энэний түрүүчийн хуралдаанууд дээр ч би хэлж байсан. Маш сайн ажилласан, хариуцлагатай, сэтгэл гаргаж. Энэ бол сая би зориуд тодотгож хэлж байгаа нь энэ анхдагч хуулийн дагуу анхны хороо томилогдож байгаа учраас бид нар их хариуцлагатай байх ёстой шүү гэж бүгдэд нь яг өөрсдийнхөө үзлээр, ойлголтоор, итгэл үнэмшлээрээ энэ ажилд хандаж, идэвхтэй санаачилгатай, хариуцлагатай ажиллаарай гэж хүссэн. Яг тэрний дагуу маш сайн ажилласан гэж бодож байгаа. Та бүхэндээ бас баярлалаа. Бид нарын ажлын үр дүн гарна байх гэж бодож байна. Тэгээд Байнгын хорооны дарга маань бас нэг үүрэг өгсөн юм. Ажлын хэсэгт орж ажилласан хүмүүстээ албан ёсоор баяр хүргээрэй гэж. Тэр баярыг нь би хүргэчихлээ.

Өнөөдрийн хуралдаан дууслаа. Амжилттай болж дууслаа. Баярлалаа та бүхэнд.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА**

